



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Судалгааны ажлын ёс зүйн журам  
батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, МУИС-ийн дүрмийн 5.4.1, 5.4.8.5 дахь заалт, МУИС-ийн захиргааны зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын шийдвэр, тэмдэглэл, МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын шийдвэр, тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “МУИС-ийн судалгааны ажлын ёс зүйн журам”-ыг хавсралтаар баталж, 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, хүний нөөцийн бодлогын газрын дарга (С.Должин)-д үүрэг болгосугай.


РЕКТОР



Д.БАДАРЧ

1424060376

МУИС-ийн Ректорын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны  
өдрийн А/01 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН СУДАЛГААНЫ  
АЖЛЫН ЁС ЗҮЙН ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Журмын зорилт

1.1.Энэхүү журмаар Монгол Улсын Их Сургууль /цаашид “МУИС” гэх/-ийн гишүүн, хүрээлэн, төвийн судлаач, эрдэм шинжилгээний ажилтны дангаар болон хамтран гүйцэтгэх, гишүүн бус бусад этгээдтэй хамтран гүйцэтгэх судалгааны ажлын ёс зүйн харилцааг зохицуулна.

1.2.МУИС-ийн гишүүн, хүрээлэн, төвийн судлаач, эрдэм шинжилгээний ажилтан нь МУИС-ийн эрхэм зорилго, стратегийн зорилтод нийцүүлэн аливаа судалгааны ажил хийж гүйцэтгэхдээ энэхүү судалгааны ажлын ёс зүйн үнэт зүйл, зарчмыг дээдлэн, ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөн ажиллаж, ёс зүйн зөрчил гаргахгүй байх үүрэгтэй бөгөөд судалгааны ажлыг хийж гүйцэтгэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2 дугаар зүйл. Үйлчлэх хүрээ

2.1.МУИС-ийн гишүүн, хүрээлэн, төвийн судлаач, эрдэм шинжилгээний ажилтан болон тэдгээрийн хамтран ажиллаж байгаа дотоод, гадаадын байгууллагуудын хийж гүйцэтгэх аливаа судалгаа, ажиглалт, сорилт, туршилт, шинжилгээ, судалгааны ажлын бүхий л үе шатанд энэхүү журмыг мөрдөж ажиллана.

2.2.МУИС-тай хамтарсан судалгаа эрхэлдэг МУИС-ийн гишүүн бус судлаач, эрдэм шинжилгээний ажилтан бусад оролцогч талууд тус журмаар тогтоосон судалгааны ажлын ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

2.3.МУИС-ийн гишүүн, хүрээлэн, төвийн судлаач, эрдэм шинжилгээний ажилтан нь МУИС-ийн гишүүн бус этгээдтэй хамтын ажиллагааны хүрээнд судалгааны ажил хийж гүйцэтгэхдээ МУИС-ийн судалгааны ажлын ёс зүйн журмыг танилцуулах бөгөөд судалгааны ажлыг гүйцэтгэх явцдаа энэхүү ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөж ажиллахыг сануулж, зөрчихөөс сэргийлэх нөхцөлийг гэрээгээр бүрдүүлнэ. МУИС-ийн гишүүн бус этгээд нь энэхүү ёс зүйн журмыг үл сахин зөрчсөн үйлдэл нь тухайн этгээдтэй хамтын ажиллагааг дуусгавар болох үндэслэл болох бөгөөд ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх нь түүнтэй байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэх шалгуур болно.

2.4.Тус журмаар нарийвчлан зохицуулснаас бусад харилцааг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/156 тоот тушаалаар батлагдсан Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрэм, МУИС-ийн дүрэм, МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журам, МУИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам, МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм, МУИС-ийн судалгааны ажлын санхүүжилтийн журам, МУИС-ийн Оюуны өмчийн

талаар баримтлах бодлого, МУИС-ийн технологи дамжуулах журам, МУИС-ийн барааны тэмдгийг ашиглах түр журам, МУИС-д эрдэм шинжилгээний ажилтан ажиллуулах журам, МУИС-д пост-доктор ажиллуулах журам, МУИС-ийн магистрант, докторантыг туслахаар ажиллуулах журам болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/156 тоот тушаалаар батлагдсан Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрэм, бусад дотоод дүрэм журам, холбогдох хууль тогтоомж, хэм хэмжээний актыг баримтлан зохицуулна.

2.5.Энэхүү журамд тусгайлан зохицуулсан судалгааны ажлын ёс зүйн харилцаанаас бусад ёс зүйтэй холбоотой харилцааг “МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм”-ээр зохицуулна.

3 дугаар зүйл. Эрхэмлэх үнэт зүйл, баримтлах зарчим

3.1.МУИС-ийн гишүүн, хүрээлэн, төвийн судлаач, эрдэм шинжилгээний ажилтан болон тэдгээрийн хамтран ажиллаж байгаа хувь хүн, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын гүйцэтгэх аливаа судалгааны ажилд энэхүү судалгааны ёс зүйн зарчмуудыг баримталж, ёс зүйн хэм хэмжээг даган мөрдөх бөгөөд судалгааг хийж гүйцэтгэхдээ эрх тэгш байх, халдашгүй байх, шашин шүтэх, эс шүтэх, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, олон ургалч байх, эвлэлдэн нэгдэх хүний суурь эрх, эрх чөлөөг эрхэмлэн судалгааны үр дүнг ашиглах бүхий л үе шатанд санаатай болон санамсаргүйгээр хууль зөрчихөөс сэргийлж ажиллана.

3.2.Санхүүжилтийн хэлбэр, төрлөөс үл хамааран МУИС-ийн нэрийн өмнөөс болон МУИС-тай хамтын ажиллагааны хүрээнд хамтран явуулж буй аливаа судалгааны ажлыг хийж гүйцэтгэх, судалгааны ажилд оролцоход судалгааны ажлын ёс зүйн дараах зарчмыг баримтална:

3.2.1.Үнэн байх: Судалгааны арга зүй, үр дүнг шударгаар үнэн бодитой мэдээлэх, судалгаанд оролцож буй хүмүүстэй шударга харьцах, аливаад үнэнийг эрхэмлэх;

3.2.2.Зөв байх: Хэлэх үг, хийх үйлдэл бүрдээ хариуцлагатай, шударга, үнэнч, зарчимч байх;

3.2.3.Баримтад тулгуурласан байх эсвэл аль нэг талд орохгүй байх: Туршилтыг төлөвлөх, өгөгдлийг шинжлэх, тайлбарлах зэрэг судалгааны үйл ажиллагааны бүхий л үе шатуудад хувийн үзэл бодол бус баримтад тулгуурлаж шийдвэр гаргах;

3.2.4.Хүндлэл: Хүн бүртэй адил тэгш харьцаж, хувийн нууц, шашин шүтлэг, онцлог, бусдаас ялгаатай байдлыг нь хүндэтгэх, байгаль, хүрээлэн буй орчиндоо хүндэтгэлтэй хандах;

3.2.5.Сайныг бусдад зориулах: Бусдын сайн сайхны төлөө, хүнлэг энэрэнгүй байх;

3.2.6.Хариуцлагатай байх: Судалгааны явцад шинэ санаа гаргахаас эхлэн өгүүлэл хэвлүүлэх хүртэл бүхий л үйл ажиллагаанд (менежмент, зохион байгуулалт, сургалт) хариуцлагатайгаар оролцох, хандах, хүний эрх, хууль тогтоомжийг санаатай болон санамсаргүйгээр үл зөрчих, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй байх;

3.2.7.Хор хөнөөлгүй байх: Хохироохгүй байх, хүнд учрах хохирол, эрсдэлийг аль болох бага байлгах, хувийн орон зай, эрх, нэр хүндэд халдахгүй байх;

3.2.8.Хариуцлагатай хэвлэн нийтлэхүй: Судалгааны үр дүн, бий болсон мэдлэгийг ойлгуулах, эрхээр хамгаалагдсан оюуны өмчийг бүтээж, хариуцлагатайгаар хэвлэн нийтлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах;

3.2.9.Хувийн мэдээллийг нууцлах ба хамгаалах: Судалгаанд оролцогчдыг ил гаргахгүй /хэн оролцож байгааг нууцлах/, хэн болохыг нь таниулж болохуйц нэр, адилтгах мэдээлэл, нийгмийн бүлэг зэрэг мэдээллийг нууцлах ба хамгаалах;

3.2.10.Нууцлал: Хувийн мэдээлэл, бүртгэл, тэмдэглэлийг нийтэд ил гаргахгүй нууцлах. Үүнд: Судалгааны танилцуулга ба зорилго, хэлэлцүүлгийн зорилго, судалгааны үйл явц, судалгааны явц дахь таамаглал, ашиг/хохирол, судалгааны ашиглагдах байдал, судалгаанд оролцогчийн үүрэг, судалгаанд оролцогчийн хувийн мэдээллийг ил гаргахгүй байх, асуултад хариулахгүй байх, судалгаанаас татгалзах, гарах эрх, судалгааны талаар нэмэлт мэдээлэл шаардлагатай үед хэнтэй холбоо барих зэрэг үйлдлүүдийг нууцлах, алдахаас сэргийлэх, хадгалах, хамгаалах;

3.2.11.Ялгаварлан гадуурхахгүй байх: Нас, хүйс, байдал, арьс өнгө, угсаа гарал болон бусад байдлаар хүнийг ялгаварлан гадуурхаж, хүний эрхийг зөрчихгүй байх;

3.2.12.Нээлттэй байх: Үр дүн, өгөгдөл, бусад мэдээллийг хуваалцахад нээлттэй байх;

3.2.13.Оюуны өмчийг хамгаалах, дээдлэх: Гарч болох алдаа, сөрөг хандлага гаргахгүй байх, бусдын оюуны өмчлөлийг дурдах. Бусдын бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, бичвэрийн талаар эшлэх, хуулбарлан давхардуулахгүйгээр өөрийн үгээр дахин илэрхийлэх;

3.2.14.Шударга ёс: Ашиг тус, саад бэрхшээлийг ижил зарчмаар тэнцүү хуваарилах, бүгдэд тэгш хандах, бусдад ялгаатай хандах шаардлага гарсан үед учир шалтгааныг тайлбарлах.

3.3.Дээр дурдсан судалгааны ажлын ёс зүйн зарчмыг баримтлаагүй, баримтлахаас татгалзсан судалгааны ажлыг МУИС санхүүжүүлэхгүй, хамтарсан судалгаанд оролцохгүй бөгөөд хамтран ажиллахаас татгалзах, судалгааны ажлыг зогсоох нөхцөл болно.

3.4.Судалгааны ажлыг хийж гүйцэтгэх явцдаа зохиогчийн эрхийн зөрчил гаргах, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдахаас ямагт сэргийлэх бөгөөд шийдвэр гаргахдаа судалгааны ажилд оролцогчдын тэгш эрхийг хангаж хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх зарчмыг баримтлан МУИС-ийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үйлдэл хийхээс сэргэмжилнэ.

4 дүгээр зүйл. Журмын нэр томьёо

4.1.Энэхүү журамд ашигласан дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“Ажиглалтын нөлөө” гэж ажиглагдаж байгаа нь судалгаанд оролцогчийн хийж буй үйлдэлд зориуд нөлөөлөхийг;

4.1.2.“Амьтан оролцуулсан судалгаа” гэж тухайн судалгаанд лабораторийн амьтан, тэжээвэр амьтан, зэрлэг амьтан, үзвэрийн амьтан оролцуулсныг;

4.1.3.“Ашиг сонирхлын зөрчил” гэж судалгааны ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгох, судалгааны ажлын ёс зүйн дүгнэлт гаргахтай холбоотой шийдвэр гаргахад нэг талыг баримталсан хандлага үүсэхэд нөлөөлж болохуйц санхүүгийн, хувийн, улс төрийн болон бусад ажил үүргээ тэгш шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлөх хувийн нөхцөл байдлыг;

4.1.4.“Ашиг хонжоо” гэж судалгааны ёс зүйн хяналтын хорооны гишүүн этгээд эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад шударга бусаар давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

4.1.5.“Био банк” гэж судалгааны зорилгоор биологийн сорьц, эд, эс хадгалах, агуулах, байр, савыг;

4.1.6.“Гомдол” гэж судалгааны ажлын ёс зүйн хяналтын хорооны шийдвэрийг эс зөвшөөрч хянуулахаар МУИС-ийн Ёс зүйн хороонд гаргасан хүсэлтийг;

4.1.7.“Дүгнэлт” гэж өргөдөл мэдүүлэгчийн судалгааны ажлын төгсгөлд ёс зүйн зөрчил гарсан эсэх талаарх судалгааны ёс зүйн хяналтын хорооны шийдвэрийг;

4.1.8.“Журам” гэж МУИС-ийн судалгааны ажлын ёс зүйн энэхүү журмыг;

4.1.9.“Зөвшөөрөл” гэж өргөдөл мэдүүлэгчийн судалгааны ажил эхлүүлэхийг зөвшөөрсөн судалгааны ёс зүйн хяналтын хорооны шийдвэрийг;

4.1.10.“МУИС-ийн багш” гэж МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрмийн 4.1.2-т заасныг;

4.1.11.“МУИС-ийн гишүүн” гэж МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрмийн 4.1.1-т заасныг;

4.1.12.“Судалгаа” гэж ажиглалт, сорилт, туршилт, шинжилгээ зэрэг судалгааны ажлыг;

4.1.13.“Судалгааны ажлын ёс зүй” гэж энэхүү журмаар тодорхойлсон шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны хүрээнд эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлыг гүйцэтгэх зарчим, ёс зүйн дэг журмыг багтаасан хэм хэмжээний нийлбэр цогцыг;

4.1.14.“Судалгааны ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх” гэж энэхүү журмыг таниулах, судалгааны ажлын ёс зүйн хэм хэмжээг сайн дураар мөрдөх ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд МУИС-ийн гишүүн, гишүүн бус хамтын ажиллагаатай этгээдийг татан оролцуулах арга хэмжээний цогцолборыг;

4.1.15.“Судлаач” гэж МУИС-д судлаач ажиллуулах журмын 1.2.1-т заасныг;

4.1.16.“Холбоо барих зохиогч” гэж “МУИС-д эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн хэвлүүлэхэд баримтлах журам”-ын Эрдэм шинжилгээний сэтгүүлийн зохиогчдод зориулсан үлгэрчилсэн зааварт заасныг;

4.1.17.“Хороо” гэж энэхүү журамд тусгагдсан Судалгааны ажлын ёс зүйн хяналтын хороог;

4.1.18.“Хамтран ажиллах гэрээ” гэж хоёр буюу түүнээс олон судалгааны багууд хамтран ажиллахаар зөвшилцсөн гэрээг;

4.1.19.“Хүн оролцуулсан судалгаа” гэж тухайн судалгаанд жирэмсэн эх, ураг, насанд хүрээгүй хүүхэд, тэгш бус харилцаанд байгаа хүмүүс, сэтгэхүйн согог, оюун ухааны хомсдол болон сэтгэцийн өвчтэй хүмүүсийг оролцуулахыг;

4.1.20.“Өргөдөл” гэж судалгааны ажил эхлүүлэх зөвшөөрөл хүсэх, эсхүл судалгааны ажил судалгааны ёс хэм хэмжээг мөрдөж ажиллаж буй болон ажилласан болохыг дүгнүүлэхээр судалгааны ёс зүйн хяналтын хороонд энэхүү журамд заасан журмын дагуу цахимаар гаргасан хүсэлтийг;

4.1.21.“Өргөдөл мэдүүлэгч” гэж судалгааны ажил эхлүүлэх зөвшөөрөл хүсэх эсхүл судалгааны ажил судалгааны ёс хэм хэмжээг мөрдөж ажилласан болохыг дүгнүүлэхээр судалгааны ёс зүйн хяналтын хороонд хүсэлт гаргасан этгээдийг;



4.1.22. "Цахим ёс зүй" гэж цахим орчинд үйлдэж буй аливаа харилцааны үед ёс зүйтэй хандахыг;

4.1.23. "Эрдэм шинжилгээний бүтээлийн хэлэлцүүлэг" гэж магистрын судалгааны ажил, докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл /диссертаци/, эрдэм шинжилгээний өгүүллэг, монограф, судалгааны ажлын тайланг хэлэлцүүлэхийг;

4.1.24. "Судалгааны баг" гэж шинжлэх ухаан, технологи, инновацийн төсөл, шинжлэх ухааны болон нийгэм-хүмүүнлэгийн салбарын суурь судалгаа, хавсарга судалгааны ажлыг гүйцэтгэхэд хамтран ажиллаж буй судлаач, эрдэм шинжилгээний ажилтнуудыг;

4.1.25. "Эрх мэдлээ урвуулан ашиглах" гэж судалгааны ёс зүйн хяналтын хорооны гишүүн хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг.

4.2. Энэхүү журамд тусгайлан тодорхойлсон дээрх нэр томъёог энд заасан утгаар ойлгож хэрэглэх бөгөөд бусад нэр томъёог тухайн харилцааг тусгайлан зохицуулсан МУИС-ийн холбогдох дүрэм, журамд тусгасан утгаар ойлгож хэрэглэнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ СУДАЛГААНЫ АЖЛЫН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

5 дугаар зүйл. Судалгааны ажлын ёс зүйн нийтлэг хэм хэмжээ

5.1. Судалгааны ажлын явцад энэхүү журамд заасан тусгайлсан судалгааны ажлын ёс зүйн хэм хэмжээнээс гадна дараах нийтлэг ёс зүйн хэм хэмжээг баримтална:

5.1.1. Үнэн, шударга ёсыг дээдэлж, аливаа асуудалд хараат бусаар бодитой хандаж, үндэслэлтэй, ил тод, эрх тэгш байдлыг эрхэмлэх;

5.1.2. Судалгаанд оролцогчдын халдашгүй байх, шашин шүтэх, эс шүтэх, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, олон ургалч байх, эвлэлдэн нэгдэх хүний суурь эрх, эрх чөлөөг эрхэмлэх;

5.1.3. Нийгмийн хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр оруулж, нийгмийн сайн сайханд үйлчлэхийг эрмэлзэх;

5.1.4. Мэргэжлийн болон МУИС, хамтрагч байгууллагын нэр хүндийг эрхэмлэх;

5.1.5. Хүний нэр төр, хувийн нууц, хуулиар хамгаалсан ашиг сонирхол, эрдмийн болоод хувийн эрх чөлөөг хүндэтгэх;

5.1.6. Бусад судлаачийн ялгаатай үзэл бодол, байр суурь, хандлагыг хүндэтгэх, судалгааны ажилд оруулсан хувь нэмрийг нь зүй ёсоор үнэлэх;

5.1.7. Судалгааны ажлын ёс зүйн эрхэмлэх үнэт зүйл, суурь зарчмуудыг хүндэтгэж, аливаа хориглосон хэм хэмжээг үйлдэхгүй байх;

5.1.8. Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн цахим ёс зүйн хэм хэмжээг мөрдөх;

5.1.9. Хүрээлэн буй орчинд хохирол учруулахгүй байх зарчмыг дээдлэн баримтлах;

5.1.10. МУИС-ийн байр, техник, тоног төхөөрөмж, сургалтын хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, эд зүйлсийг зүй зохистой, гамтай ашиглах;

5.1.11. Судалгааны багийн гишүүдийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага, оролцоог хамтран ажиллах гэрээгээр баталгаажуулах бөгөөд хамтран ажиллах гэрээгээ шударгаар даган мөрдөх.

6 дугаар зүйл. Судалгааны ажлын ёс зүйн тусгайлсан хэм хэмжээ

6.1.Судалгааны ажилд хүн оролцуулахад дараах тусгайлсан ёс зүйн хэм хэмжээг баримтална:

6.1.1.Судалгааны үйл ажиллагаа нь судалгаанд оролцогчдод сэтгэл зүй, бие махбодын хувьд аюул, эрсдэл учруулахгүй байх;

6.1.2.Жирэмсэн эх болон ургийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг судалгааны эрх ашгаас үргэлж дээгүүр тавих;

6.1.3.Аливаа байгууллагын хэрэглэгч, үйлчлүүлэгчийг судалгаанд хамруулахдаа байгууллагын санд байгаа үйлчлүүлэгчийн мэдээллийг дамжуулах, өвчтөний мэдээллийг ашиглах тухай зөвшөөрөл авч байх;

6.1.4.Эрүүл мэндийн байгууллагын үйлчлүүлэгчийг судалгаанд хамруулах зөвшөөрлийг авахад эрүүл мэндийн байгууллагын ажилтнаар дамжуулахгүй байх;

6.1.5.Судалгааны зорилгоор цуглуулсан мэдээлэл нь байгууллагын санд байгаа үйлчлүүлэгчийн мэдээллийг оролцуулахгүйгээр тусад нь ашиглаж болохуйц байх;

6.1.6.Судалгаанд хамрагдах зөвшөөрөлд гарын үсэг зурж зөвшөөрсөн ч судалгааны явц дууссан, дуусаагүй аль ч үед хүссэн үедээ түдгэлзэх эрхтэй гэдгийг судалгаанд оролцогчдод ойлгуулах, сануулсан байх;

6.1.7.Судалгаанд оролцогчийн хувийн мэдээлэлд хүндэтгэлтэй хандаж нууцыг хадгалах ба хувийн мэдээллийг судалгаанд оролцогчийн зөвшөөрөлгүйгээр ашиглахгүй байх;

6.1.8.Судалгааны үед цуглуулсан аливаа мэдээлэл, тэр дундаа генетикийн холбогдолтой мэдээлэл нь дараагийн үед (generation) нөлөөлөх магадлалтайг анхаарч болгоомжтой хандах.

6.2.Судалгааны ажилд жирэмсэн эх болон ургийг оролцуулахад дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална:

6.2.1.Судалгааны үйл явцын алхам бүрийг, мөн судалгааны үед болон хүүхдээ төрүүлсний дараа эх хүүхдэд нөлөөлж болох нөхцөл байдал, эрсдэл, мөн үүсэж болох нөхцөл байдалтай холбоотой зөвлөх үйлчилгээний талаар жирэмсэн эмэгтэйд мэдэгдэх;

6.2.2.Судалгаанд хамаатай байж болох бусад хүнийг судалгаанд оролцуулах эсэхийг жирэмсэн эхээс урьдчилан асуух;

6.2.3.Урагт үзүүлэх сөрөг нөлөө, өвдөлт, стресс зэргийг аль болох багасгаж, байж болох хамгийн бага түвшинд судалгааны ажлыг зохион байгуулах ба тэдгээр шинж тэмдгийг тогтмол ажиглах, бүртгэх мөн шаардлагатай үед судалгааг хэрхэн зогсоох алхмуудыг нарийвчлан төлөвлөсөн байх;

6.2.4.Өвчний шалтгааныг тодруулах, оношлох, эмчлэх ач холбогдолтой биш л бол, урагт гаж нөлөө үзүүлж болохуйц эмийн болон бусад судалгааг жирэмсэн эмэгтэй, урагт хийхгүй байх;

6.2.5.Жирэмсэн эх, урагтай холбоотой судалгааны үйл явц нь тэдний жирэмсний болон эрүүл мэндийн хяналтаас тусдаа байх;

6.2.6.Жирэмслэлтийг зогсоох болсонтой холбоотойгоор үр хөврөлийг цаашид судалгаанд ашиглах асуудлыг жирэмслэлтийн үйл явцаас тусад нь авч үзэх ба энэ үед эхээс эсвэл итгэмжлэгдсэн хүнээс таниулсан зөвшөөрлийг авахдаа жирэмслэлтийг зогсоох шийдвэр гарч, ажилбар дууссанаас хойш хандах;

6.2.7.Эхээс зөвхөн байгалийн жамаар төрсөн эсхүл хууль ёсны ажилбараар салгасан үр хөврөлийг судалгаанд ашиглах;

6.2.8.Жирэмслэлтийг зогсоохтой холбоотой ажилбарыг гүйцэтгэгч эмнэлгийн ажилтан нь албан ёсны эрх бүхий мэргэжилтэн байх ба судалгаанд оролцогч биш (санхүүгийн ашиг сонирхол агуулаагүй) байх;

6.2.9.Судалгаанд оролцогчид судалгаанд ашиглах үр хөврөлийг хадгалах эсэх, тийм бол хэр хугацаанд хадгалах, хэрхэн тээвэрлэх талаар урьдаар мэдэгдэх;

6.2.10.Жирэмсэн эх судалгаанд оролцохоор гарын үсэг зурсан таниулсан зөвшөөрлөө жирэмсэн байх явцдаа ч жирэмслэлтийг зогсоосны дараа ч өөрийн хүсэлтээр буцаан авч, судалгаанаас гарч болно гэдгийг судалгаа эхлэхээс өмнө урьдчилж мэдэгдэх.

6.3.Судалгааны ажилд насанд хүрээгүй хүүхдийг оролцуулахад дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална:

6.3.1.Насанд хүрээгүй хүүхдийг зайлшгүй нөхцөлд л судалгаанд хамруулдаг байх;

6.3.2.Насанд хүрээгүй хүүхдийг судалгаанд оролцуулах үед эцэг эх, асран хамгаалагчаас заавал таниулсан зөвшөөрөл авсан байх;

6.3.3.Насанд хүрээгүй хүүхэд судалгаанд оролцохыг хүсэхгүй, эсвэл судалгаанд оролцож байгаад болихыг хүсвэл түүний хүсэлтийг хүндэтгэх бөгөөд хүүхдийг судалгаанд хамруулах эсвэл үргэлжлүүлэн хамруулах нь өвчний оношилгоо, эмчилгээг сайжруулах, хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой бол эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг урьдчилан бичгээр авч судалгааг үргэлжлүүлэх;

6.3.4.Насанд хүрээгүй хүүхдийг судалгаанд хамруулахдаа судалгаанд хамрагдах хүүхдэд судалгааны явц, зорилгыг нас сэтгэхүйн онцлогт тохируулан (тодорхой нас заах нь тохиромжгүй юм) өөрт нь танилцуулахаас гадна хүүхэд болон эцэг эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл авсан байх;

6.3.5.Насанд хүрээгүй хүүхэд жирэмсэлсэн үед ч насанд хүрээгүй хүүхдийг судалгаанд хамруулахтай холбогдох заалтыг баримталсан байх;

6.3.6.Боловсролын зорилгоор буюу сургалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хийж байгаа судалгаанд тухайн жилд сургуулийн зүгээс зохион байгуулалттайгаар эцэг эх, асран хамгаалагчаас авсан хугацаатай зөвшөөрлийг ашиглах боломжтой үед эцэг эх, асран хамгаалагчаас дахин зөвшөөрөл авахгүй байх, зөвшөөрлийн хугацааг сунгасан байж болно.

6.4. Судалгааны ажилд адил тэгш бус буюу нэг нь нэгнээсээ хараат эсхүл давуу эрх эдлэх магадлал бүхий харилцаатай дараах этгээдийг оролцуулахад дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг баримтална:

6.4.1.Адил тэгш бус буюу нэг нь нэгнээсээ хараат эсвэл давуу эрх эдлэх магадлалтай харилцаатай дараах иргэд, байгууллагуудаас судалгаа авахдаа онцгой анхаарал тавьж ажиллах ёстой. Үүнд:

6.4.1.1.Асран халамжлагч болон хүнд өвчтэй, урт хугацаанд хүний асаргаанд байгаа өвчтөн хоорондын;

6.4.1.2.Эрүүл мэндийн ажилтан болон өвчтөн, үйлчлүүлэгч хоорондын;

6.4.1.3.Багш болон суралцагчийн хоорондын;

6.4.1.4.Хорих ангийн удирдлага болон хүмүүжигчийн хоорондын;



- 6.4.1.5.Төрийн байгууллагын удирдлага болон дүрвэгсэд хоорондын;
- 6.4.1.6.Ажил олгогч болон ажилтны хоорондын (цагдаа, хүчний байгууллагууд мөн хамаарна);
- 6.4.1.7.Үйлчилгээ үзүүлэгч, ханган нийлүүлэгч болон тухайн үйлчилгээг авч буй этгээдийн аль нэг нь өөрөө судалгаа авч байгаа, эсвэл ямар нэг байдлаар оролцож байгаа талууд бүгд хамаарна.
- 6.4.2.Ямар ч тохиолдолд судлаач нь тэгш бус харилцаанаас үүсэж болох нөлөөлөл, үр дагаврыг багасгахад анхаарч ажиллах;
- 6.4.3.Бусдаас хараат, тэгш бус харилцаа нь тухайн хүн судалгаанд оролцох шийдвэр гаргахад нөлөөлөх магадлалыг тооцоолсон байх;
- 6.4.4.Судалгаанд оролцох шийдвэр гаргахын өмнө тус шийдвэр гаргахад нь туслах боломжтой хэн нэгэнтэй зөвшилцөх боломж олгоно. Зөвшилцөх боломжгүй эсвэл өөрөө бие даан шийдвэр гаргах чадамжгүй бол өмгөөлөгчид нь хандсан байх;
- 6.4.5.Судалгаанд хамруулах нь хялбар байх магадлалтай учраас дээрх бүлгийн хүмүүсийг судалгаанд хэт олноор оролцуулахаас сэргийлэх арга хэмжээ авах;
- 6.4.6.Судалгаанд оролцохоос татгалзсан, эсхүл судалгааг зогсоосон аль ч тохиолдолд судалгаанд оролцогчийн нөхцөл байдал өмнөхөөс буурахгүй байх ёстойг анхаарч, анхаарал халамж буурах, шударга бус хандах, ялгаварлах, тухайлбал ажлаас нь халах зэрэг сөрөг үр дагавар гарахаас сэргийлэх;
- 6.4.7.Бусдаас хараат оролцогчийг судалгаанд хамруулахдаа түүнийг бие даасан иргэн хүн хэмээн хүндэлж хандах;
- 6.4.8.Судалгаанд оролцогчийн талаарх бүх мэдээллийг чанд хадгалах, алдагдуулахгүй байх тал дээр хатуу анхаарах.
- 6.5.Судалгааны ажилд таниулсан зөвшөөрөл өгөх чадамжгүй оролцогчийг оролцуулахад дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална.
- 6.5.1.Судалгаанд оролцох зөвшөөрөл өгөх чадамжгүй оролцогчид гэж дараах хүмүүсийг ойлгоно:
- 6.5.1.1.дөнгөж төрсөн нярай;
- 6.5.1.2.хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдаж байгаа өвчтөн;
- 6.5.1.3.яаралтай тусламж авч буй өвчтөн;
- 6.5.1.4.сэхээн амьдруулах тасагт эмчлүүлж буй өвчтөн;
- 6.5.1.5.өөрийн ухаангүй байгаа өвчтөн.
- 6.5.2.Судалгаа нь тухайн бүлэг хүний болон өвчний нөхцөл байдлыг ойлгох, сайжруулах боломжийг нэмэгдүүлэх зайлшгүй ач холбогдолтой үед л эдгээр хүнийг судалгаанд хамруулна.
- 6.5.3.Таниулсан зөвшөөрөл өгөх чадамжгүй хүнийг судалгаанд оролцуулахдаа шаардлагатай хууль тогтоомжийг заавал мөрдлөг болгох;
- 6.5.4.Судалгаанд оролцогчийн гэр бүлийнхэнтэйгээ хамт өнгөрөөх цагийг хүндэтгэх;
- 6.5.5.Судалгааны явц, судалгааны зорилгоор хийж буй бүхий л үйлдлийг судалгаанд оролцогчдод заавал мэдэгдэх;
- 6.5.6.Яаралтай тусламж үзүүлж байх үед өвчтөнийг судалгаанд хамруулбал тухайн судалгаанд хамаатай эмчилгээ, үйлчилгээнээс өмнө өвчтөнөөс өөрөөс нь эсвэл асран халамжлагчаас нь таниулсан зөвшөөрөл авах;

6.5.7.Өөрийн ухаангүй байгаа өвчтөнийг зөвхөн тухайн өвчтөний эмчилгээний үр дүн, эрүүл мэндийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор зайлшгүй тохиолдолд л судалгаанд хамруулна.

6.6.Судалгааны ажилд сэтгэхүйн согог, оюуны ухааны хомсдол, болон сэтгэцийн өвчтэй хүмүүсийг оролцуулахад дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална:

6.6.1.Сэтгэхүйн согог, оюун ухааны хомсдол, сэтгэцийн өвчтэй хүмүүс нь судалгаанд оролцох эрхтэй байх бөгөөд судлаач мэдээлэл хүлээж авах, судалгаанд оролцохыг зөвшөөрөх, оролцох зэрэгт нөлөөлж болохуйц байнгын болон түр зуурын хүчин зүйлсийг судалгаандаа харгалздаг байх;

6.6.2.Судлаач судалгаанд оролцогчийн сэтгэцийн онцлогийг харгалзан стрессдэх зэрэг таагүй нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, хяналтдаа байлгана, нэгэнт таагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд түүний сөрөг үр дагаврыг багасгах арга замыг судалгааны саналд дурдсан байх;

6.6.3.Сэтгэхүйн согог, оюун ухааны хомсдол, сэтгэцийн өвчтэй хүнийг судалгаанд оролцуулахдаа тухайн хүн зөвшөөрөх чадамжтай бол өөрөөс нь, чадамжгүй бол эцэг эх, асран хамгаалагч, эсвэл хууль ёсны итгэмжит төлөөлөгч хувь хүн эсвэл байгууллагаас зөвшөөрөл авсан байх;

6.6.4.Эцэг эх, асран хамгаалагч, эсвэл хууль ёсны төлөөлөгчөөс нь зөвшөөрөл авах, судалгаанд хэрхэн оролцуулах, хүссэн үедээ судалгааг зогсоох эрхтэйг тайлбарлах;

6.6.5.Түр зуурын болон урт хугацааны аль ч хэлбэрийн сэтгэцийн өөрчлөлт нь судалгааны зөвшөөрөл хүсэх үед судалгаанд оролцогчийн шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөхүйц байж болохгүй. Шийдвэр гаргах үйл явцыг тухайн судалгааны үйл явц, учирч болох эрсдэлийг ойлгох чадамжтай, судалгааны багт хамаарахгүй, боломжтой бол судалгаанд оролцогчийг (өвчтөнийг) таньдаг, сэтгэцийн өөрчлөлтийнх нь нөхцөл байдлыг сайн мэддэг хүнээр гэрчлүүлэх;

6.6.6.Сэтгэхүйн согог, оюун ухааны хомсдол, сэтгэцийн өвчтэй хүнийг хэрхэн тодорхойлох, хэн шийдвэр гаргах, тухайн шийдвэрийг гаргахад мөрдөх шалгуур, оролцохыг зөвшөөрөх чадамжийг хянах процессыг урьдчилж мэдэгдэх;

6.6.7.Сэтгэхүйн согог, оюун ухааны хомсдол, сэтгэцийн өвчтэй хүн судалгаанд оролцохоос татгалзах, дургүйцэх үед оролцогчийн хүсэлтийг хүндэтгэх.

6.7.Судалгааны ажилд амьтан оролцуулахад дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална:

6.7.1.МУИС-ийн гишүүн, тэдгээртэй хамтарсан байгууллага амьтныг ашигласан сургалт, туршилт болон судалгаа явуулахдаа МУИС-ийн гишүүдийн ёс зүйн дүрэм, судалгааны ёс зүйн үзэл баримтлал, эрдэм шинжилгээний ажилтны ёс зүй, био анагаахын ёс зүй болон бусад дүрэм, журамд заасан хэм хэмжээг хатуу баримтлах;

6.7.2.Амьтан оролцуулахгүйгээр сургалт, туршилт, судалгааны үр дүнг үнэн, бодитой гаргаж (гений инженерчлэл, шугаман эсийн өсгөвөр, серологийн болон молекул биологийн арга, дархлааны хамгаалах хариу урвалыг шалгах арга, харшил сорилын тестийн арга ашиглаж) болох эсэх талаар сайтар судлан үзэж, шаардлагатай тохиолдолд л амьтан оролцуулсан судалгаа хийх;

6.7.3.Амьтан оролцуулсан аливаа судалгааны ажил эхлүүлэхээс өмнө холбогдох мэргэжлийн сургалт, семинарт заавал хамрагдсан байх;

6.7.4.Амьтныг туршилт, сургалт, судалгаанд оролцуулах тохиолдолд судалгааны ёс зүйн хяналтын хорооны зөвшөөрлийг авсан байх;

6.7.5.Лабораторийн туршилт, сургалт, судалгаанд зөвхөн гарал үүсэл нь тодорхой, зөвшөөрөлтэй газар бойжуулсан амьтдыг оролцуулах;

6.7.6.Амьтдыг туршилт, сургалт, судалгаанд ашиглахдаа дараах 3R зарчмыг баримталсан байх. Үүнд:

6.7.6.1.Орлуулах (Replacement) - Туршилтад заавал амьтдыг оролцуулахгүйгээр дэвшилтэт арга, технологи ашиглан амьтан бус биологийн материалаар орлуулах эсвэл компьютер болон математик тооцоолон бодох аргуудыг хэрэглэхийг эрмэлзэх;

6.7.6.2.Багасгах, цөөрүүлэх (Reduction) - Туршилтад ашиглах амьтдын тоог цөөрүүлэх, шаардлагагүй тохиолдолд амьтны амь таслахаас зайлсхийх;

6.7.6.3.Нөхцөлийг сайжруулах (Refinement) - Туршилт, сургалт, судалгаанд оролцож буй амьтдыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх, ая тухтай стрессгүй орчинд байлгах, зөв арчлах, хооллох, аль болох өвдөлтөөс ангид байлгах боломжтой арга техникийг туршилтад ашиглах.

6.7.7.Амьтныг хээлтэй байх үед болон төллөх үед амьдралын таатай, тохиромжтой нөхцөлд байлгана. Хэрэв энэ үед туршилт хийх шаардлага тохиовол эх амьтан болон үр төлд энэрэнгүй хандах;

6.7.8.Хэрэв амьтныг барих бол энэрэх сэтгэлээр хандаж, амьтанд хор хөнөөл учруулж болзошгүй дэгээ, хавх болон бусад багаж хэрэгсэл хэрэглэхгүй байх;

6.7.9.Амьтныг тээвэрлэх, ялангуяа алс хол тээвэрлэх явцад улирал, цаг уурын нөхцөлийг харгалзан тухайн тохиолдолд тавигдах эрүүл орчны шаардлагыг бүрэн хангасан байх;

6.7.10.Туршилт, сургалт, судалгаа хийж буй газар амьтны биеийн болоод сэтгэл зүйн таатай нөхцөлийг бий болгосон байх;

6.7.11.Туршилтад ашиглах амьтны төрөл, зүйл, нас, хүйс зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж сонголтоо зөв хийсэн байх;

6.7.12.Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд, тухайн амьтанд учрах эрсдэлүүдийг сайтар тооцсоны үндсэн дээр туршилтыг оновчтой төлөвлөсөн байх;

6.7.13.Туршилтын дараах үед амьтныг ая тухтай газар байрлуулж, асарч тэжээж, өвдөлт, зовуурьгүй байлгах нөхцөлийг бүрдүүлсэн байх;


6.7.14.Хэрэв туршилт, сургалт, судалгааны явцад урьдчилан таамаглаагүй нөхцөл үүсэж, амьтны амийг таслах шаардлага тулгарсан үед аль болох амьтныг тарчлаан зовоохгүй байх;

6.7.15.Лабораторийн туршилтад хэрэглэсэн амьтны гаралтай сэг, зэм, биологийн гаралтай дээжүүдийг хаях эсхүл устгалд оруулахдаа халдварт өвчин тархахаас сэргийлж автоклавдаж ариутгасны дараагаар био-аюулын таних тэмдэг бүхий уутанд хийж шууд устгалын нэгж/компанид өгдөг байх;

6.7.16.Устгалын нэгж/компанид шууд шилжүүлэх боломжгүй тохиолдолд шилжүүлэх хүртэл хөлдөөж хадгалах;

6.7.17.Лабораторийн бус мал амьтны хүүр, сэг зэмийг устгахдаа хот суурин газар луу тээвэрлэхгүй, MNS 6406:2013 стандартыг дагаж мөрдөн ажиллах;

6.7.18.Туршилт, сургалт, судалгаанд аливаа үзэгдлийг тайлбарлаж үзүүлэхийн тулд амьд амьтныг оролцуулахаас аль болох татгалзах.



6.8. Судалгааны ажилд судалгааны өгөгдлийг ашиглахад дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална:

6.8.1. Өгөгдөл, мэдээлэл болон датаг үүсгэх, цуглуулах, ашиглах, шинжлэх, нээлттэй тайлагнах, хадгалах, хаях, хуваалцах, устгахдаа судлаачид энэ журмын 5.1.8-д заасан хэм хэмжээг баримтлах;

6.8.2. Судалгааны өгөгдлийн хэлбэрүүдэд хувийн болон нийтийн өгөгдөл, хувь хүний болон албан байгууллага, институцтэй холбоотой дата, амьтад, ургамал, хөрс, ус гэх зэрэг байгалийн болон биологийн нөөцүүдийн өгөгдөл орох бөгөөд зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй юм. Үүнд: түүвэр судалгаа, фокус бүлгийн ярилцлага, хувийн түүх, намтар, дүрс бичлэг, аудио бичлэг, албан хэрэгцээгээр цуглуулсан тайлан, протокол, өвчний түүх, геномын мэдээлэл, био банк, цахим өгөгдөл, их өгөгдөл орох;

6.8.3. Хүнтэй холбоотой аливаа өгөгдлийг цуглуулах, ашиглах, тайлагнахдаа “Хувь хүний нууцын тухай хууль”-ийн 5 дугаар зүйл, “Статистикийн тухай хууль”-ийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг нэн тэргүүнд баримталж хувь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хангаж хүний хувийн мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрлөөр цуглуулах;

6.8.4. Амьтад болон био нөөцтэй холбоотой аливаа өгөгдлийг судалгаанд ашиглахдаа “Генетик нөөцийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйл, “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг нэн тэргүүнд баримталж зөвшөөрөл авсны үндсэн дээр өгөгдөл, мэдээллийг цуглуулах;

6.8.5. Судлаач өгөгдөл цуглуулахдаа анхан шатны бус хоёрдогч эх үүсвэрийн өгөгдлийг ашиглах тохиолдолд тухайн өгөгдлийг эзэмшиж байгаа хувь хүн, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын зөвшөөрлийг авсан байх;

6.8.6. Хүнтэй холбоотой аливаа өгөгдлийг цуглуулах, ашиглах, тайлагнахдаа хувь хүний мэдээллийг (овог, нэр, төрсөн он, сар, өдөр, регистрийн дугаар зэргийг) нууцалж, кодолж ашиглах;

6.8.7. Хүнтэй холбоотой аливаа өгөгдлийг цуглуулах, ашиглах, тайлагнахдаа хувь хүний хүсэлтээр (судлаачид, идэвхтэн тэмцэгчид, олонд танил хүмүүс гэх мэт) хувийн мэдээллийг нууцлахгүйгээр ашиглах тохиолдолд судлаачид болон судалгаанд оролцогч хувь хүмүүс мэдээллийн ил болгох хувь хэмжээг тохиролцон тодорхойлж, хоорондын гэрээ хийсэн байх;

6.8.8. Ирээдүйд үүсэж болзошгүй маргаан, эрх зүйн асуудлуудаас зайлсхийхийн тулд судлаачид, хамтарсан багууд судалгааны зорилгоор бүрдүүлсэн өгөгдлийг цуглуулах, ашиглах, шинжлэх, хадгалах, дахин ашиглах, бусдад дамжуулах, борлуулах, устгах үе шатуудын өмчлөлийн талаар тодорхой зөвшилцөлд хүрсэн байх, хамтран ажиллах гэрээнд тусгасан байх;

6.8.9. Судлаачид, хамтарсан багууд судалгааны зорилгоор цуглуулсан өгөгдлийг дахин ашиглах, бусдад дамжуулах, нээлттэй платформд тавих үе шатанд уг өгөгдлүүдийг анх цуглуулах үед өгсөн зөвшөөрлийн бичгийн хамрах хугацаа, цар хүрээ өөрчлөгдсөн байх тул энэ талаар уг өгөгдлийг анх цуглуулахдаа тодорхой зөвшилцөлд хүрсэн байх;

6.8.10. Судлаач судалгааны зорилгоор цуглуулсан өгөгдлийг Судалгааны ёс зүйн хяналтын хорооны зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах, худалдах;



6.8.11. Судлаач судалгааны зорилгоор цуглуулсан өгөгдлийг устгах, үгүй болгохдоо тухайн судалгааны объектын хувийн мэдээллийг заавал устгаж байж устгалд оруулах;

6.8.12. Судлаач хувийн мэдээллийг буруугаар ашиглах, дур мэдэн засварлах буюу задруулах, компьютерын вирус болон хохирол учруулах бусад эх үүсвэрээр дамжуулан алдахаас сэргийлж ажиллах.

7 дугаар зүйл. Хамтарсан судалгааны ажлын ёс зүйн хэм хэмжээ

7.1. Хамтарсан судалгааг салбар дотроо, салбар хоорондын болон байгууллага дотор, байгууллага хоорондын судлаачид хэрэгжүүлж болох бөгөөд хамтран ажиллах гэрээ/санамж бичиг байгуулсан байна.

7.2. Хамтарсан судалгаа санаачлах, хэрэгжүүлэхийн тулд хамтын ажиллагааны гэрээ байгуулахдаа МУИС-ийн гадаад хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ байгуулах, түүнийг хэрэгжүүлэх, дүгнэх журмыг баримтална.

7.3. Хамтарсан судалгаа хийх судалгааны багт судлаачид зөвхөн өөрийн саналын үндсэн дээр орж ажиллана.

7.4. Судалгааны баг нь хувь хүний болон санхүүгийн ашиг сонирхлын зөрчилгүй багийг бүрдүүлсэн байна. Судалгааны хамтрагчид нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэл бүхий аливаа харилцаа холбоо, үйл ажиллагааг заавал үнэн зөв мэдээлнэ.

7.5. Судалгааны баг нь харилцан зөвшилцлийн дүнд багийн ахлагч/төлөөлөгч (representative) томилох бөгөөд багийн ахлагч/төлөөлөгч нь судалгааны ажлын ёс зүйн бичиг баримтыг мэдүүлнэ.

7.6. МУИС-ийн санхүүжүүлсэн, эсвэл төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдтэй МУИС-ийн байгуулсан гэрээт судалгааны ажлын хүрээнд бий болсон судалгааны өгөгдөл, үр дүнг эзэмшигч нь МУИС байна. Судалгааны баг, хамтрагчид нь судалгааны өгөгдөл, үр дүнг эзэмшихгүй, харин цуглуулах, ашиглах, дүн шинжилгээ хийх онцгой эрх бүхий хамгаалагч байна. Судалгааг санхүүжүүлэгч гэрээт байгууллага нь судалгааны өгөгдөл, үр дүнг тодорхой зорилгоор ашиглах эрхтэй байна.

7.7. Бусад эх үүсвэрээс санхүүжилттэй судалгааны ажлын үр дүнд бүтээгдсэн оюуны өмчийг эзэмших, захиран зарцуулахтай холбоотой асуудлыг санхүүжүүлэгчтэй байгуулсан судалгааг санхүүжүүлэх гэрээг үндэслэн шийдвэрлэнэ.

7.8. Олон улсын байгууллага, их сургуультай хамтарсан судалгааг гүйцэтгэхэд тухайн улсын хууль, дүрэм, журам, соёл, ёс зүйн хэм хэмжээг харгалзан үзэж, хамтрагч бүрд нийцтэй ёс зүйн хэм хэмжээ, судалгааны зохистой арга зүйг баримтална.

7.9. Судалгааны үр дүнд бий болсон өгөгдөл, холбогдох материалууд нь тухайн судалгааны хамтрагчдад нээлттэй байна. Судалгааны хамтрагчид нь судалгааны явц, судалгаанаас бий болсон өгөгдлийн үнэн зөв байдалд харилцан хяналт тавьж, нээлттэй харилцааг эрхэмлэнэ.

7.10. Хамтарсан судалгааны явцад хамтрагчдын үйлдсэн ёс зүйн зөрчлийг мэдээлэх, шаардлагатай арга хэмжээг авч, шийдвэрлэх ёстой.

7.11. Хамтарсан судалгаанд оролцож буй судлаач, судалгааны ажил явагдах байгууллага /лаборатори, сургууль, хүрээлэн г.м/ болон санхүүжүүлэгчийн тухайн судалгаанд оруулах хувь нэмэр, судалгааны ажилтай холбоотой эрх, үүргийг

хамтрагчид хэлэлцэж тодорхойлон хамтран ажиллах гэрээгээр баталгаажуулсан байна. Ингэхдээ дараах мэдээллийг заавал тусгана:

7.11.1.төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнг үнэлэх аргачлал;

7.11.2.хамтрагчдын эрх, үүрэг, оролцооны хэлбэр, судалгааны багийн ахлагч/төлөөлөгч, түүний эрх, үүрэг;

7.11.3.оюуны өмч бүтээх, эзэмшихтэй холбоотой тохиролцоо, шийдэл;

7.11.4.нууцлалтай холбоотой тохиролцоо, шийдэл (шаардлагатай тохиолдолд нууц хадгалах гэрээ);

7.11.5.санхүүжилтийн мэдээлэл;

7.11.6.нөөцийг хэрхэн хуваалцах тухай мэдээлэл (resource sharing);

7.11.7.шаардлагатай тохиолдолд дээж, материалыг шилжүүлэх, зөөх тухай мэдээлэл (material transport);

7.11.8.хамтрагчид хоорондоо судалгааны өгөгдөл хуваалцах зарчим, арга зам; ашиг сонирхлын зөрчилгүй гэсэн баталгаа (conflict of interest);

7.11.9.холбогдох хууль, дүрэм, журмуудтай танилцсан бөгөөд даган мөрдөнө гэсэн баталгаа (compliance with applicable regulations);

7.11.10.зохиогчдын оролцоо, зохиогчдын нэрс бичигдэх дарааллыг шийдэхэд баримтлах зарчим (authorship and publication practices);

7.11.11.хамтрагчдын үйлдсэн судалгааны ёс зүйн зөрчлийг илрүүлэх, мэдэгдэх, шийдвэрлэхийн тулд авах арга хэмжээ.

7.12.Хамтарсан судалгааны үр дүнг хэвлэн нийтлүүлэх, эрдэм шинжилгээний хуралд илтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж түгээх, сурталчлахын өмнө тухайн судалгаанд оролцсон хамтрагчид хэлэлцэж, бүгд зөвшөөрч бичгээр баталгаажуулсан байна. Судалгааны үр дүнгийн үнэн зөв, ёс зүйн зөрчилгүй байдалд хамтрагч бүр хариуцлага хүлээнэ.

7.13.Хамтарсан судалгааны явц, үр дүнгийн талаарх мэдээллийг судалгаанд оролцсон хамтрагчдын зөвшөөрөлгүйгээр нийтэлж, түгээж болохгүй.

7.14.Хамтарсан судалгааны үр дүнг хэвлэн нийтлүүлэхэд судалгааны багийн гишүүд зохиогчоор бичигдэх бөгөөд судалгааны багийн ахлагч зөвшөөрсөн нөхцөлд судалгаанд зохих хэмжээний хувь нэмэр оруулсан этгээдийг оруулж болно. Энэ зөвшилцлийг 7.12-д заасан хэсэгт зөвшөөрөлд тодорхой дурдсан байна. Зарчимд нийцэхүйд хэмжээний хувь нэмэр оруулаагүй хамтрагчийг зохиогчоор оруулах, эсвэл хувь нэмэр оруулсан хамтрагчийг зохиогчоор оруулалгүй хасахыг хориглоно.

7.15.Хамтарсан судалгааны үр дүнг хэвлэн нийтлүүлэх, эрдэм шинжилгээний хуралд илтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж түгээх, сурталчлахдаа судалгааны хамтрагчид болон санхүүжүүлэгчийг нээлттэй зарлана.

7.16.Хамтын ажиллагаа үргэлжлэх хугацаа нь хамтарсан судалгаа дуусах хугацаатай ижил байх албагүй бөгөөд гэрээгээр тогтооно. Харилцан зөвшилцлийн дүнд судалгааг сунгах, шинэчлэх боломжтой байна.

8 дугаар зүйл. Зохиогчийн эрхийн ёс зүйн хэм хэмжээ

8.1.Аливаа судалгааны байгууллага стандартад нийцэхгүй зохиогчийн эрхийн практикаас урьдчилан сэргийлэх шаардлагатай. Үүнд:

8.1.1.Залуу судлаачид ахлах мэргэжилтнээ өөрсдийн бүтээлд нь оюуны чухал хувь нэмэр оруулсан эсэхээс үл хамааран зохиогчоор оруулбал бүтээлийнх нь үнэн баттай байдал нэмэгдэнэ гэж бодох;

8.1.2.Залуу судлаачид ажил, судалгааны боломж, албан тушаал ахихад нь тодорхойлолт өгөх талд дээр чухал нөлөө бүхий дарга нараа гомдоохыг хүсээгүй байх;

8.1.3.Ахлах судлаачид нь хамтрагчийнхаа бүтээлд бусад үүрэг хариуцлагаасаа болоод шууд хувь нэмэр оруулж чадаагүй ч бүтээмж сайтай судлаач болж харагдахыг хүсэх;

8.1.4.Хамтрагчид зөвхөн арын албаны зохицуулалт, санхүү, захиргааны дэмжлэг үзүүлснийхээ хариуд зохиогч болж бичигдсэн байх;

8.1.5.Өөрийн бүтээлийг хулгайлах (Self-plagiarism). Нэгэнт хэвлүүлсэн бүтээлээ дахин хэвлүүлэх гэж байгаа бол зохиогч түүндээ шинэ санаа, тайлбар, тодруулга нэмэлтээр оруулж, эхний болон удаах хэвлэлийн газрын редакторуудаар зөвшөөрүүлсэн байх;

8.1.6.Давхардуулж хэвлэх (Redundant publication). Зохиогч хэвлэмэл болон цахим хэлбэрээр нэгэнт нийтлэгдсэн бүтээлтэйгээ бараг ижил утга агуулгатай зохиол дахин хэвлүүлэх;

8.1.7.Хэсэгчлэх (Fragmentation) буюу (ажлын бүтээмжээ арвин харагдуулах). Гэхдээ судалгааны ажил нь хэт нүсэр, өөрөөр хэлбэл хэмжээний хувьд том, агуулгын хувьд их нарийвчлалтай бол тухайн судлаачийн хувьд энэхүү ажлын үр дүнг хэсэгчлэн хэвлүүлэхээс өөр аргагүй байсныг энд харгалзан үзэх шаардлагатай.

8.2.Зохиогчийг тодорхойлох энэхүү хэм хэмжээ нь оюуны бүтээлийн зохиогчийн жагсаалтад хэнийг оруулах, тэдний нэрийг жагсаан бичих дарааллын талаар гарах маргааныг шийдвэрлэхэд тустай байна.

8.3.Зохиогчийн эрхийн талаар санал зөрөлдөөн нь оролцогч хувь хүмүүсийн сайхан сэтгэл, бүтээмж, нэр хүнд, эрдмийн хамт олонд ихээхэн хохирол учруулдаг тул эрдмийн нийгэмлэг бүхэлдээ зохиогчийн эрхийн стандартын талаар тодорхой ойлголттой болсноор ийм санал зөрөлдөөнийг урьдчилан сэргийлэх боломжтой болно.

8.4.Үг эсвэл дүрс; цаасан эсвэл цахим; хэвлэгдсэн эсвэл явцуу хүрээнд ашиглахаар бэлдсэн; шинжлэх ухааны юм уу хүмүүнлэгийн ухааны чиглэлээр; шинэ нээлт, санааг түгээх, одоо байгаа мэдлэгийг тоймлон хэвлэх, эсвэл боловсролын хөтөлбөрүүдийг тоймлох зорилготой эсэхээс үл хамааран оюуны бүх бүтээлд ижил зарчим үйлчилнэ.

8.5.Зохиогч болж жагсаалтад орсон судлаачид тухайн бүтээлд чухал, шууд, оюуны хувь нэмэр оруулсан байх буюу үзэл баримтлал, загвар, өгөгдлийн дүн шинжилгээ эсвэл нэмэлт тайлбарт ямар нэгэн хэмжээгээр хувь нэмэр оруулсан байна.

8.6.Зохиогчийн жагсаалтад хүндэт юм уу зочин зохиогчийг хүлээн зөвшөөрөхгүй байх. Санхүүжилт олох, техникийн үйлчилгээ, өвчтөн, материалаар хангах нь тухайн бүтээлд амин чухал байж болох ч энэ нь дангаараа зохиогчийн эрхийг үндэслэх хангалттай хувь нэмэр болохгүйг анхаарна.

8.7.Зохиогчийн жагсаалтад тухайн бүтээлд оюуны чухал нэмэр оруулсан хүн бүр зохиогч байх бөгөөд зохиогчоор ороогүй боловч чухал хувь нэмэр оруулсан хүн бүрд талархал илэрхийлнэ.

8.8.Зохиогчийн жагсаалтад судалгааг маш нарийн мэргэшсэн гишүүн бүхий баг хийж гүйцэтгэсэн бол хувь хүний оруулсан хувь нэмэр, үүрэг хариуцлага нь ажлын

тодорхой хүрээгээр хязгаарлагдаж болно. Нооргийг нягтлан үзэж, эцсийн хувилбарыг зөвшөөрөх байдлаар бүх зохиогч гар бичмэлийг бичихэд оролцсон байна.

8.9.Холбоо баригч зохиогч нь зохиогчийн эрхийн үндсэн стандартыг бүх зохиогч хангаж байгаа эсэхийг баталгаажуулж, бүх зохиогчийн хүлээн зөвшөөрсөн, бүтээлд тэдний оруулсан хувь нэмрийг илтгэсэн товч тодорхойлолтыг бэлтгэнэ. Уг баримтууд нь ивээн тэтгэгч тэнхим, хүрээлэн, судалгааны төвд үлдэнэ.

8.10.Зохиогчийн дарааллыг тодорхойлохдоо тухайн судлаачдын оролцоог бодитоор эрэмбэлнэ.

8.11.Холбоо баригч зохиогч нь зохиогчийн дараалал хэрхэн шийдсэн талаарх товч, бичгээр үйлдсэн тодорхойлолт бэлдэх бөгөөд зохиогчийн эрхийн талаарх маргааныг тус журмын 8.9 дэх заалтад заасан тодорхойлолтыг үндэслэн зохиогч нар өөрсдөө шийднэ. Хэрэв зохиогч нар зохих шийдэлд хүрээгүй бол МУИС-ийн Ёс Зүйн Хороонд хандаж шийдвэрлүүлнэ.

8.12.Зохиогч болон зохиогчийн харьяалагдах институт нь тухайн бүтээлд нөлөө үзүүлэх боломжтой ямар нэг байгууллагатай санхүүгийн болон бусад харилцаатай нь нотлогдсон үед түүнийг ашиг сонирхлын зөрчил үүссэн гэж үзнэ. Ашиг сонирхлын зөрчил үүссэн үед бүтээлийг хэвлэхгүй, хэвлэлийн дараа нотолгоо гарч ирсэн бол бүтээлийг эргүүлэн татах эрх бүрдэнэ.

8.13.Зохиогч Хельсинкийн Тунхаглалын дагуу судалгаанд оролцсон хүн бүрийг ямар байдлаар судалгаанд оролцож, дэмжлэг үзүүлсэн болон судалгааны объект болсон зэргийг бүтээлдээ заавал дурдан оруулах ёстой.

8.14.Судалгаанд амьтныг ямар нэг байдлаар объект болгон ашигласан бол холбогдох ёс зүйн комиссын баримталж буй зарчмын дагуу ажиллах ёстой бөгөөд, ямар зарчмын дагуу тухайн амьтдад судалгаа хийснийг бүтээлдээ дэлгэрэнгүй дурдах шаардлагатай.

8.15.Зохиогчийн эрх нь МУИС-ийн бүх судлаачийн заавал үзэх судалгааны ёс зүйн хичээлийн нэг бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд шинжлэх ухааны судалгаа, зохиогчийн эрхийн тухайд орчин үеийн хандлагыг харгалзан үзэж, сайжруулж ажиллана.

9 дүгээр зүйл. Үргэлжлүүлэн хийж байгаа судалгааны ажлын хэм хэмжээ

9.1.МУИС дээр хийгдэж буй төсөл/судалгааны ажил тодорхой шалтгааны (өөр ажилд томилогдох, эрүүл мэндийн хүндэтгэх шалтгаан, нас нөгчих, удирдагчийн ёс зүйн зөрчил гэх мэт) улмаас тухайн удирдагч/баг уг судалгааны ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд тухайн багийн гишүүд эсвэл өөр судлаач, судалгааны баг уг судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийх; бусад судлаачийн өмнө нь гарган авсан өгөгдөл, судалгааны материалыг үргэлжлүүлэн ашиглах; тухайн оюутны судалгааны ажлыг удирдагчийн зүгээс үргэлжлүүлэн удирдах боломжгүй болсон тохиолдолд өөр хүн удирдах эсхүл оюутны өөрийн хүсэлтээр судалгааны өөр удирдагч сонгож буй зэрэг ойлголтуудыг хамруулан ойлгоно.

9.2.Үргэлжлүүлэн хийж буй судалгааны ёс зүйн хэм хэмжээ нь МУИС-ийн гишүүдийн бие даан хийж буй судалгаа болон МУИС-тай хамтран гүйцэтгэж буй судалгааны ажлууд тэдгээрт оролцож буй гишүүдэд эрх тэгш үйлчилнэ.

9.3.Төсөл/судалгааны удирдагч тодорхой шалтгааны улмаас солигдсон тохиолдолд:



9.3.1.Хамтарсан байдлаар хэрэгжиж буй төсөл/судалгааны төслийн удирдагч солигдвол аль судлаач, судалгааны баг төсөл/судалгааг үргэлжлүүлэн удирдах талаар багууд хоорондоо байгуулах гэрээ/санамж бичигт тодорхой тусгана;

9.3.2.Судалгааны дараагийн удирдагчийг судалгааны багаас томилох зарчмыг баримтлахыг эрхэмлэнэ;

9.3.3.Шинээр томилогдож буй судалгааны удирдагчид судалгааг үргэлжлүүлэх, хэвлэн нийтлэхтэй холбоотой төсөл, судалгааны ажлын санхүү, менежмент болон бусад бүх эрх, үүрэг шилжинэ;

9.3.4.Шинээр томилогдож буй удирдагч эсвэл судалгааны баг өмнөх багын гаргасан алдаа, дутагдлын хариуцлагыг хүлээхгүй байх.

9.4.МУИС-ийн гишүүд нь МУИС-тай хамтарсан санхүүжилтээр судалгааны ажлын үр дүнд гарган авсан өгөгдөл, судалгааны материалыг (хээрийн, лабораторийн туршилтын дээжүүд, илүү гарсан материал, техник, тоног төхөөрөмж, бодис, урвалж гэх мэт) үргэлжлүүлэн ашиглах тохиолдолд:

9.4.1.Өгөгдөл бол энэ журмын 8 дугаар хэсэгт заасан хэм хэмжээг баримтална;

9.4.2.Судалгааны материалыг үргэлжлүүлэн ашиглах бол эзэмшигчтэй тодорхой зөвшилцөлд хүрсэн байх шаардлагатай ба МУИС-ийн оюуны өмчийн талаар баримтлах бодлогын заалтуудыг мөрдөнө.

9.5.Судалгааны ажил үргэлжлүүлэн хийх, удирдах бол:

9.5.1.Тодорхой шалтгааны улмаас эрдэм шинжилгээний ажлын удирдагч үргэлжлүүлэн удирдах боломжгүй болсон тохиолдолд суралцагч шинээр удирдагч сонгох эрхтэй;

9.5.2.Удирдагчийн зүгээс гаргасан ёс зүйн алдааны улмаас суралцагч судалгааны ажлаа үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд удирдагчаас татгалзах, шинээр удирдагч сонгох эрхтэй;

9.5.3.Суралцагчийн зүгээс гаргасан ёс зүйн алдааны улмаас удирдагч тухайн оюутны судалгааны ажлыг удирдахаас татгалзах эрхтэй.

10 дугаар зүйл. Судалгааны санхүүжилтийн ёс зүйн хэм хэмжээ

10.1.Судлаач нар судалгааны санхүүжилтийг аливаа хүн, байгууллагын (төрийн, төрийн бус, хувийн, олон улсын, хандив, тусламжийн, санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг, санхүүжилтийг авахдаа ашиг сонирхлын зөрчилд үл автах, хөндлөнгийн нөлөөлөлд үл автан шийдвэр гаргах үүрэгтэй.

10.2.Судалгааны өгөгдөл цуглуулах, өгөгдөлд нэвтрэх, ашиглах, шинжлэх, хадгалах, судалгаанд оролцогчидтой уулзах боломжоор хангаж байгаа болон санхүүжүүлж байгаа аливаа хүн, байгууллагын санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг, санхүүжилтийг хамтран ажиллах гэрээгээр баталгаажуулна.

10.3.Судалгаанд оролцсонтой холбоотойгоор судлаач болон судлуулагчдыг даатгалд хамруулах, хэрвээ тэд гэмтэх, хөдөлмөрийн чадвараа алдах, нас барах зэрэг тохиолдолд олгох нөхөн төлбөр, хийх эмчилгээний зардал, хохирол барагдуулах талаар хамтран ажиллах гэрээнд тусгасан байх үүрэгтэй.

10.4.Судлаач, судалгааны баг, санхүүжүүлэгч нарт тухайн судалгаанд хэрэглэхэд тохирсон арга, үе шатууд, гарсан үр дүнг мэдээлэх, хуваалцах, өмчлөх талаар бүрэн дүүрэн, нээлттэй, үнэнчээр мэдээлэх үүрэгтэй.

10.5.Судлаач болон судалгааны баг тухайн судалгааны санхүүжүүлэгч нарын тухай мэдээлэл болон санхүүжүүлэгчтэй хийсэн гэрээний ашиг сонирхлын зөрчилгүй байгаа талаарх мэдээлэл, судалгаанд оролцохтой холбоотойгоор ямар нэг урамшуулал (мөнгө, бараа, үйлчилгээ, бэлэг дурсгал) хөнгөлөлт, нөхөн олговрын талаар, гаднын байгууллагатай хамтарсан буюу санхүүжилт авч байгаа бол тухайн байгууллагын ёс зүйн хяналтын институцийн зөвшөөрлийг судалгаа эхлэхээс өмнө зөвшөөрөл авах өргөдөлд үнэнчээр мэдээлэх үүрэгтэй.

10.6.Судлаач болон судалгааны баг санхүүжүүлэгч нарын тухайн судалгаанд ёс зүйн журмыг зөрчих, үндэслэлгүй арга хэрэглэх, гарсан үр дүнг гуйвуулахыг тулгаж болзошгүй нөхцөлүүдийг хүлээж авахгүй, татгалзах үүрэгтэй.

10.7.Судалгааны санхүүжилт болон судалгаа, шинжилгээний зориулалттай нийтийн эзэмшлийн техник, багаж, тоног төхөөрөмжийг зөвхөн зориулалтын дагуу ашиглана. Үүнд: судалгааны ажилд оролцоогүй судлаач нар болон оролцогч нарт судалгааны төсвийн дагуу уг үе шатуудад төлөвлөгдсөн санхүүжилтээс олгохгүй байх үүрэгтэй.

10.8.Судалгааны санхүүжилтийн талаар үнэн зөв тайлагнах, судалгааны оюуны өмчийн эрх, мэдээлэл, өгөгдлийн нууцад хүндэтгэлтэй хандах үүрэгтэй.

11 дүгээр зүйл. Судалгааны ажлын ёс зүйн хориглох хэм хэмжээ

11.1.МУИС-ийн гишүүн, хүрээлэн, төвийн судлаач, эрдэм шинжилгээний ажилтан нь судалгааны ажлын явцад дараах үйлдлийг хийхийг хатуу хориглоно:

11.1.1.Судалгааны ажилд оролцож буй хүний хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй тараах, бусдад дамжуулах, худалдах;

11.1.2.Судалгаанд ашигласан амьтадтай энэрэнгүй бус хандах, зовоон тарчлаах, зүй бусаар хороох;

11.1.3.Судалгааны өгөгдлийг хуурамчаар бүрдүүлэх, бодитоор гарсан үр дүнг болон өгөгдлийг засах, гарсан үр дүнг санаатайгаар орхигдуулах, ажлын үр дүнгийн талаар санаатайгаар худал мэдээлэх;

11.1.4.Судалгааны явцад болон үр дүнд бий болсон хаягдлыг байгаль орчинд халтай, хортой байдлаар хаях, орхих;

11.1.5.Бусдын хийсэн ажлын үр дүнг хуулбарлах, санаатай болон санамсаргүйгээр оюуны өмчийн хууль тогтоомжийг зөрчих;

11.1.6.Судалгааны санхүүжилтийг зориулалтын бус байдлаар зарцуулах;

11.1.7.Туршилт, судалгааны үр дүнд бий болоогүй, зохиомлоор бий болгосон өгөгдөл, дүгнэлтийг боловсруулах, хуурамчаар үйлдэх, ажиглалтын нөлөө гаргахгүй байх, судалгааны ажлыг амжилттай болгох зорилгоор гарсан үр дүнг засах;

11.1.8.Судалгаа, шинжилгээний зориулалттай нийтийн эзэмшлийн техник, тоног төхөөрөмжийг зориулалтын бус байдлаар ашиглах;

11.1.9.Судалгааны ололт, үр дүнг хүн, нийгмийн эсрэг болон хувийн явцуу зорилгод урвуулан ашиглах;

11.1.10.Судалгааны баг, судлаач өөрийн санал хүсэлтээр биш бусдын нөлөөн дор орж ажиллах;

11.1.11.Судалгааны баг үүсгэхдээ хувь хүний болон санхүүгийн ашиг сонирхлын зөрчил, хувийн сонирхол, өс хонзон, эрдэм шинжилгээний өрсөлдөөн үүсгэх;

11.1.12.Судалгааны багт ажиллахдаа гэрээ, хэлэлцээрийн шаардлагыг баримтлахгүй байх;

11.1.13.Хамтын судалгааны явц, үр дүнгийн талаарх мэдээллийг багийн зөвшөөрөлгүйгээр нийтлэх, түгээх;

11.1.14.Эрдэм шинжилгээний бүтээлийн хэлэлцүүлэгт оролцохдоо танил тал, байгууллагын харьяалал, багш шавийн холбоо, ашиг сонирхлоос хамаарах;

11.1.15.Хэлэлцүүлгийн явцад гардаг маргаан мэтгэлцээнд оролцохдоо бусдыг доромжлох, сэтгэл зүйн хувьд дарамтлах зэрэг үйлдэл гаргах;

11.1.16.Хэлэлцүүлгийн өмнө болон явцад нь хэлэлцэж буй бүтээлийн талаар хувийн санал бодлоо бусдад тулгах, далдуур хуйвалдах үйл ажиллагаа явуулах;

11.1.17.Шинээр томилогдсон эрдэм шинжилгээний ажлын удирдагч болон суралцагч судалгааны ажлаа үргэлжлүүлэх үйл явцад хөндлөнгөөс оролцох, гүтгэх, сэтгэл зүйн дарамт үзүүлэх, нэр төрд халдах болон өөр бусад хэлбэрээр саад учруулах;

11.1.18.Судалгааны ажлын ёс зүйн зөрчлийн талаар ёс зүйн хяналтын хороонд мэдэгдэх үүргээ биелүүлэхгүй байх, нуун дарагдуулах.

11.2.Эрдмийн зэрэг, цол, албан тушаалын зэрэглэл, ажилласан жил, харьяалал, суралцаж буй түвшин, бүрэлдэхүүн сургууль, арьсны өнгө, нас, хүйс, бэлгийн хандлага, улс төрийн үзэл баримтлал, намын харьяалал, үзэл бодол, шашин шүтлэг, ажил хэргийн санал зөрөлдөөн үүсгэхээс зайлсхийж хууль тогтоомжийг баримтлан энэхүү журмыг хэрэгжүүлнэ.

11.3.МУИС-ийн гишүүн, хүрээлэн, төвийн судлаач, эрдэм шинжилгээний ажилтны хүлээсэн эрх, үүрэгт үндэслэлгүйгээр халдаж эрх зүйн байдлыг дордуулах, МУИС-ийн дүрэм, журамд заасан эрх, үүрэгт сөргөөр нөлөөлөх, саад болох, аливаа ялгаварлан гадуурхах байдлаар энэхүү журмыг хэрэглэх, шийдвэр гаргах, судалгааны ажлыг ангилах, эрэмбэлэхийг хатуу хориглоно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### СУДАЛГААНЫ АЖЛЫН ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ

#### 12 дугаар зүйл. Хорооны чиг үүрэг

12.1. МУИС-ийн хэмжээнд, МУИС-ийн гишүүн, хүрээлэн, төвийн судлаач, эрдэм шинжилгээний ажилтны хийх аливаа судалгаа, туршилт, ажиглалт, шинжилгээний үед баримтлах судалгааны ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, судалгаанд оролцож буй субъектүүдийн аюулгүй байдлыг хамгаалах, судлаачдыг эрх зүйн талаарх аливаа асуудлаас хамгаалах үүрэгтэй судалгааны ажлын ёс зүйн хяналтын хороо /цаашид “Хороо” гэх/ ажиллах бөгөөд хороо нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.1.1.МУИС-ийн судалгааны ажлын ёс зүйн журмын хэрэгжилтийг ханган ажиллах;

12.1.2.МУИС-ийн хэмжээнд хийх аливаа судалгаа, туршилт, ажиглалт, шинжилгээний үед баримтлах судалгааны ёс зүйн журам болон хэм хэмжээг сахин мөрдүүлэх;

12.1.3.Судалгааны ёс зүйг түгээн сурталчлах, судалгааны ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнээс үүдэх эрсдэлийг багасгах, судалгаанд оролцож буй субъектүүдийн аюулгүй байдлыг хамгаалах;

12.1.4.Холбогдох өргөдөл мэдүүлэгчийн өргөдлийг хүлээн авч, судалгааны ажил нь энэхүү журмын ёс зүйн хэмжээнд нийцэх эсэхийг тогтоон шийдвэрлэж зөвшөөрөл олгох, дүгнэлт гаргах;

12.1.5.Судалгааны ёс зүйн зөвшөөрөл авахад бүрдүүлэх бичиг баримт, эрсдэлийн үнэлгээний хуудас, лабораторийн амьтан дээр судалгаа хийхэд бүрдүүлэх материал, судалгааны ёс зүйн зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын мэдүүлэг, өргөдөл мэдүүлэгчид олгох гэрчилгээний загвар зэргийг өөрчлөх, шинэчлэх.

12.2.Хороо нь судалгааны ёс зүйг баримтлах дэлхий нийтэд зөвшөөрөгдсөн олон улсын зөвлөмж, эрх зүйн зохицуулалт, Монгол Улсад хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, МУИС-ийн хэмжээнд хэрэгжиж буй МУИС-ийн гишүүн, хүрээлэн, төвийн судлаач, эрдэм шинжилгээний ажилтан болон тэдгээрийн хамтран ажиллаж байгаа дотоод, гадаадын байгууллагуудын хийж гүйцэтгэх судалгааны ёс зүйн асуудлыг хэлэлцэж судалгаа эхлэхээс өмнө хэлэлцэж зөвшөөрөл олгох ба судалгааны төгсгөлд ёс зүйн дүгнэлт гаргана.

12.3.Хорооны бүтэц, бүрэлдэхүүн, санхүүжилт, зохион байгуулалт, ажиллах журмыг энэхүү журмаар зохицуулна. Хороо нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй.

12.4.Хороо нь олон улсын болон үндэсний хэмжээнд судалгааны ёс зүйн чиглэлээр гаргасан хууль зүйн акт, дүрэм, журам, зөвлөмж, сайн жишгийг мөрдөж, судалгааны ажилд олон улсын болон үндэсний хэмжээний ёс зүйн хэм хэмжээг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж дүгнэлт гаргаж ажиллах, аливаа алдаа, дутагдал гарахаас сэргийлэх үүрэгтэй бөгөөд судалгааны ажлын арга аргачлалын шинжлэх ухаанч байдал, ёс зүйн хэм хэмжээ, судалгааны удирдамжийг (протокол) хэлэлцэж судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх, судлагдахууны эрх ашиг, хувийн нууц, аюулгүй байдлын талаар баримтлах ёс зүйн зарчим, хэм хэмжээг хэрхэн хангах талаар мэдээлэл өгч, сургалт явуулах, эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагааг явуулна.

12.5.Хороо нь хамтын ажиллагаатай гадаадын их сургууль, судалгааны байгууллага, олон улсын байгууллагын хамтарсан судалгааны төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд судалгааны ёс зүйн зөвшөөрөл олгож болно.

12.6.Хороо нь судалгааны ажлын ёс зүйн чиглэлээр МУИС-ийн суралцагч, багш, судлаачдад зориулсан судалгааны ёс зүйн талаарх удирдамж, гарын авлага гаргах, сургалт зохион байгуулж, ёс зүйн зөвлөгөө өгч байх үүрэгтэй байх ба судалгааны ёс зүйн чиглэлээр дэлхийн томоохон их дээд сургуулиудад хэрэгжүүлдэг жишгээр сургалтыг улиралд багадаа 2 удаа цахимаар зохион байгуулна.

12.7.Хороо нь судалгааны ажил, төсөл хөтөлбөрийг эхлэхээс өмнө урьдчилан зөвшөөрөл олгох, судалгааны ажлын явц болон төгсгөлд хяналт, шалгалт хийж дүгнэлт гаргах ба судалгааны ажлыг түдгэлзүүлэх, цуцлах, зогсоох эсхүл судалгааны ажлын удирдамжид өөрчлөлт оруулахыг шаардах эрхтэй.

12.8.Хүн оролцуулсан судалгааны ажилд хүнийг хүндэтгэх, хувь хүний болон байгууллагын нууцыг хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, үр ашигтай



байх, хүн, амьтан, байгаль орчинд хор хөнөөлгүй, тэгш хандах зарчмыг баримталж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.

12.9.Амьтан оролцуулсан судалгааны ажилд амьтны амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, зовоон тарчлаахгүй егүүтгэх зарчмыг баримталж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.

12.10.Химийн, биологийн бодис хэрэглэсэн туршилт, шинжилгээг юун түрүүнд хүнд аюулгүй байх, байгууллага, байгаль орчинд хор хөнөөлгүй байгаа эсэхийг тогтоож үнэлэлт өгнө.

12.11.Археологи, палеонтологи, түүх, төрийн нууцад хамаарах асуудлаар хийх судалгааны ажилд холбогдох хууль тогтоомжийг мөрдсөн эсэхэд үнэлэлт өгнө.

12.12.Энэ журмын 12.8, 12.9, 12.10, 12.11 дэх хэсэгт заасан судалгааны ажилд Хорооны зөвшөөрөл, дүгнэлтийг заавал авна.

12.13.Хороо нь олон улсын судалгааны ёс зүйн хяналтын хороодын гишүүнчлэлтэй байж болно.

12.14.Хороо нь хавсралтаар баталж дүрсэлсэн дэс дарааллын дагуу ажиллана.

13 дугаар зүйл. Хорооны бүтэц, бүрэлдэхүүн

13.1.Хороо нь дарга, нарийн бичгийн дарга, 5 гишүүнээс бүрдсэн 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

13.2.Хорооны дарга, гишүүдийг 3 жилийн хугацаатай сонгоно.

13.3.Хороо нь нарийн бичгийн даргатай байна. Хорооны нарийн бичгийн даргыг хорооны гишүүдийн саналыг үндэслэн МУИС-ийн захирал томилно.

13.4.Хорооны нарийн бичгийн дарга нь орон тооны байх бөгөөд бусад гишүүд нь орон тооны бус байна.

13.5.Хорооны дэргэд хяналт хийхэд мэргэжлийн дүгнэлт өгөх зорилготой санал өгөх эрхтэй хөндлөнгийн хараат бус 8 шинжээчийг ажиллуулна. Хорооны гишүүдийг үндсэн бүрэлдэхүүн, хорооны гишүүд, шинжээчдийг хамтад нь бүрэн бүрэлдэхүүн гэж үзнэ.

13.6.МУИС-ийн Эрдмийн зөвлөл нь судалгаа болон сургалтын нэгжээс санал болгож буй хорооны гишүүнд нэр дэвшигчдийн дундаас өөр өөр салбарыг төлөөлсөн, судалгааны ёс зүйн мэдлэг, туршлагыг харгалзан, хүйсийн тэнцвэртэй байдлыг бүрдүүлэн хорооны гишүүдийг сонгон шалгаруулна. Хорооны хуралд оролцсон гишүүдийн нууц санал хураалтын үндсэн дээр олонхын саналаар Хорооны даргыг сонгоно.

13.7.МУИС-ийн Эрдмийн зөвлөл нь Хорооны дарга, гишүүд болон сургалт, судалгааны нэгжүүдээс санал болгож буй хорооны шинжээчид нэр дэвшигчдийн дундаас амьтан ургамал, байгаль орчин, инженерчлэл, био-анагаахын хийгээд эдийн засаг, нийгмийн зан үйлийн болон бусад салбарын төлөөлөл байх, боловсрол, ажлын туршлага, мэргэжлийн хувьд мэргэшсэн байх шалгуураар шинжээч нарыг сонгон шалгаруулна.

13.8.Хорооны гишүүд, шинжээч нарыг МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

13.9.Хорооны дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, шинжээч нарыг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас эсвэл өөрийн хүсэлтээр чөлөөлөх тохиолдолд нөхөн сонгон шалгаруулалт явуулна. Шинжээч гишүүдийн 1/3-ийг 1.5 жил тутам шинэчилж болно.

13.10.Хорооны дарга нь гишүүд, шинжээчдийг үүрэгт ажлаа гүйцэтгэж эхлэхээс өмнө судалгааны ёс зүйг магадлах ажилд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх баталгааг бичгээр урьдчилан баталгаажуулж авна.

13.11.Хорооны гишүүд нь үйл ажиллагаа явуулахдаа дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална:

13.11.1.Хуулийг дээдэлж, олон улсын болон үндэсний хэмжээнд судалгааны ёс зүйн чиглэлээр гарсан баримт бичиг, журмыг мөрдлөг болгон, ёс зүйн зөрчил гаргахгүй байх;

13.11.2.Энэхүү журам болон “МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм”-ийг сахих;

13.11.3.Ашиг сонирхлын зөрчлөөс ангид бие даасан хараат бус байх.

13.12.Хорооны дарга, гишүүд нь МУИС-ийн профессор, дэд профессор, нарийн бичгийн дарга нь докторын зэрэгтэй байна.

13.13.Хорооны дарга дараах үүрэг хүлээнэ:

13.13.1.Хорооны үйл ажиллагааг зохион байгуулах;

13.13.2.Хорооны ээлжит болон ээлжит бус хурлыг зарлах, хурал даргалах;

13.13.3.Судалгааны ажлын эрсдэл бага гэж үзсэн тохиолдолд хороог үндсэн гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр зарлан хуралдуулж, шуурхай хяналтыг хийлгэх;

13.13.4.Судалгааны ажлын эрсдэл ихтэй гэж үзсэн тохиолдолд хороог бүрэн бүрэлдэхүүнтэйгээр зарлан хуралдуулж, шийдвэр гаргуулах;

13.13.5.Шаардлагатай үед тодорхой асуудлаар дүгнэлт гаргуулах зорилгоор хөндлөнгийн мэргэжлийн шинжээчийг нэмж томилох;

13.13.6.Хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих;

13.13.7.Хорооны хурлын тэмдэглэл, зөвшөөрөл, дүгнэлт, гэрчилгээнд гарын үсэг зурж баталгаажуулах;

13.13.8.Хурлын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

13.13.9.Хорооны гишүүн тус журамд заасан чиг үүргийг биелүүлээгүй, ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн эсхүл хичээлийн жилд хорооны хурлын 1/3-ийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан тохиолдолд хугацаанаас өмнө чөлөөлөх саналыг МУИС-ийн захиралд хүргүүлэх;

13.13.10.Гишүүд, шинжээчдийг үүрэгт ажлаа гүйцэтгэж эхлэхээс өмнө судалгааны ёс зүйг магадлах ажилд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх баталгааг бичгээр авах.

13.14.Хорооны нарийн бичгийн дарга дараах үүрэг хүлээнэ:

13.14.1.Хорооны даргын удирдлага дор хорооны дотоод үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах;

13.14.2.Хорооны дарга, гишүүд, шинжээч, өргөдөл мэдүүлэгч болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулах;

13.14.3.Хорооны бичиг хэргийг хариуцан хөтлөх, гишүүд, шинжээчдэд мэдээлэл хүргэх;

13.14.4.Судалгааны ёс зүйн эрсдэлийн түвшнийг хавсралтад заасан загварын дагуу үнэлэх;

13.14.5.Хорооны даргад тодорхой асуудлаар дүгнэлт гаргуулах хөндлөнгийн шинжээчийг санал болгох;

13.14.6.Хорооны хурлын бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон ёс зүйн зөвшөөрөл авах, дүгнэлт гаргахад шаардлагатай бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, гишүүдэд хурал эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

13.14.7.Хорооны хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих, МУИС-ийн Ёс Зүйн Хороонд шилжүүлэх;

13.14.8.Хорооны хурлын шийдвэрийг МУИС-ийн <http://num.edu.mn> сайтад байршуулах;

13.14.9.Хорооны үйл ажиллагааны орлого, зардлын тайланг санхүүгийн жил тутам гаргах;

13.14.10.Судалгааны ёс зүйн талаарх сургалт, соён гэгээрүүлэх ажлыг хариуцах;

13.14.11.Хорооны бичиг баримтыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу архивлан хадгалах.

13.15.Хорооны гишүүн дараах үүрэг хүлээнэ:

13.15.1.Хорооны үйл ажиллагаа, зохион байгуулалтын асуудлаар саналаа илэрхийлэх;

13.15.2.Хорооны хуралд хэлэлцэж буй асуудлаар санал хэлэх, санал өгөх;

13.15.3.Судлаачдын судалгааны ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгох, хянах, ёс зүйн шаардлага хангаагүй судалгааны ажлыг түдгэлзүүлэх, зогсоох, дүгнэлт гаргах, санал оруулан шийдвэрлүүлэх;

13.15.4.МУИС-д хэрэгжиж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны ажил, төсөл, хөтөлбөртэй танилцаж хуралд санал оруулах;

13.15.5.Шаардлагатай тохиолдолд өргөдөл мэдүүлэгчээс шийдвэр гаргахад нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга шаардаж авах;

13.15.6.Хорооны гишүүнээс татгалзах;

13.15.7.Хорооны хурлын хамтын шийдвэрийг хүндэлж мөрдөх;

13.15.8.Хорооноос өгсөн үүрэг, даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх;


13.15.9.Хэлэлцэж буй асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй бол санал хураалтад үл оролцох;

13.15.10.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүйд хүрвэл хурал болохоос нэг хоногийн өмнө дарга эсвэл нарийн бичгийн даргад мэдэгдэх.

14 дүгээр зүйл. Хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт

14.1.Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна. Хурлыг хорооны дарга удирдан явуулна.

14.2.Ээлжит хурлыг сар бүрийн 3 дахь долоо хоногийн баасан гарагт хуралдахаар товлож зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зарлан хуралдуулна. Хурлыг танхим болон цахим, эсвэл холимог байдлаар хийж болно.



14.3.Хороо нь өргөдөл мэдүүлэгчийн судалгааны ажлын эрсдэлийн түвшнээс хамааран ёс зүйн хяналтыг шуурхай, бүрэн бүрэлдэхүүнээр хийнэ.

14.4.Хорооны дарга шаардлагатай гэж үзсэн нөхцөлд хорооны гишүүн бус хөндлөнгийн мэргэжлийн шинжээч томилон судалгааны ажлын тодорхой асуудлаар дүгнэлт гаргуулан авч болно.

14.5.Хороонд өргөдөл мэдүүлэгчээс шаардлагатай тохиолдолд судалгааны ажлын талаар нэмэлт мэдээлэл авна.

14.6.Зөвшөөрөл авах болон дүгнэлт гаргуулах өргөдөл мэдүүлэгч нь хавсралтад заасан бүрдүүлбэрийн дагуу өргөдөл болон холбогдох материалыг бүрдүүлж цахимаар өргөдөл гаргана.

14.7.Хороо бүрдүүлэх материал дутуу, нэмэлт баримт материал, тайлбар шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хэлэлцүүлгийг хойшлуулна.

14.8.Хорооны нарийн бичгийн дарга нь өргөдөл болон дагалдах материалыг хүлээн авч, бүрэн бүтэн, шаардлага хангасан эсэхийг урьдчилан хянан магадалж, шаардлага хангасан гэж үзвэл тухайн судалгааны ажлын эрсдэлийн түвшнийг тодорхойлно.

14.9.Хорооны дарга нарийн бичгийн даргаас тухайн судалгааны ажлын эрсдэлийг тооцсон эхний үнэлгээ болон холбогдох материал хүлээн авч хяналтыг дараах байдлаар хийнэ. Үүнд:

14.9.1.Судалгааны ажлын ёс зүйн асуудлыг эрсдэл бага гэж үзсэн тохиолдолд хорооны үндсэн гишүүдийн бүрэлдэхүүнтэй шуурхай хяналтыг хийх;

14.9.2.Судалгааны ажлын ёс зүйн асуудлыг эрсдэлтэй буюу эрсдэл өндөр гэж үзсэн тохиолдолд бүрэн бүрэлдэхүүнээр хурлыг хуралдуулж хяналт хийх.

14.10.Хороо дүгнэлт гаргахад зайлшгүй шаардлагатай нэмэлт баримт бичиг, тайлбар тодруулга шаардлагатай гэж үзсэн нөхцөлд өргөдөл мэдүүлэгчээс хугацаа тогтоон нэмэлт материал шаардсаны үндсэн дээр хяналтыг хийж болно.

14.11.Ашиг сонирхлын зөрчил гарахаас сэргийлж судалгааны ажилтай холбоотой асуудлаар тухайн өргөдөл мэдүүлэгч судлаач болон судалгааны багийн гишүүн, судалгааг санхүүжүүлэгчтэй хамааралтай гишүүн санал хураалтад оролцохыг хориглоно.


14.12.Хуралд хорооны нийт гишүүдийн 2/3 дээш хувь оролцсоноор хүчинтэйд тооцно.

14.13.Хэлэлцэж буй асуудлын талаар хуралдаанд оролцож буй гишүүдийн 2/3 хувиас дээш дэмжсэн тохиолдолд батална.

14.14.Хороо хуралдаж, өргөдөл мэдүүлэгчийн судалгааны ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгох эсвэл судалгааны төгсгөлд ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн, зөрчил бий эсэх асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргана.

14.15.Хорооны хурлаар зөвшөөрөл, дүгнэлт гаргуулахаар хүсэлт гаргасан судалгааны ажил нь ёс зүйн зөрчил гаргасан эсэх асуудлыг холбогдох журмын дагуу шалгахдаа судалгааны ёс зүйн хэм хэмжээ зөрчигдсөн байж болзошгүй тухайн асуудлаар Хороонд хандах бөгөөд Хороо нь бүрэн бүрэлдэхүүнээр хуралдаж тухайн асуудлаар тухайлсан дүгнэлт гаргаж тогтоосон хугацаанд МУИС-ийн Ёс зүйн хороонд шилжүүлнэ.

14.16.Хурлаас хурлын тэмдэглэл, зөвшөөрөл эсвэл дүгнэлт гаргаж, тусгайлан дугаарлаж албан маягт дээр хэвлэж олгоно. Өргөдөл мэдүүлэгч хүссэн нөхцөлд





зөвшөөрөл, дүгнэлтийг хураангуйлсан англи, монгол хэл дээр үйлдсэн гэрчилгээ олгож болно. Гэрчилгээнд Хорооны дарга гарын үсэг зурж тэмдэг дарж баталгаажуулах бөгөөд Хорооны нарийн бичгийн дарга хариуцан гүйцэтгэнэ. Гэрчилгээний загварыг хороо батална.

14.17.Хороо нь шаардлагатай тохиолдолд МУИС-ийн тамга, тэмдэг, албан маягтыг ашиглаж болно.

14.18.Хурлын шийдвэрийг нарийн бичгийн дарга хурал болсноос хойш ажлын 14 өдрийн дотор өргөдөл мэдүүлэгчид цахимаар хүргүүлж, холбогдох шийдвэр, мэдээллийг МУИС-ийн <http://num.edu.mn> сайтад байрлах хорооны цахим хуудсанд байршуулна.

14.19.Хороонд бүрдүүлж өгсөн материал, хурлын тэмдэглэл, зөвшөөрөл, дүгнэлтийг хууль тогтоомжид заасан журмын дагуу архивлан хадгална.

14.20.Хорооны үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг хорооны нарийн бичгийн дарга болон МУИС-ийн дүрэм журамд заасан холбогдох албан тушаалтанд цахим хаягаар илгээх болон цаасан хэлбэрээр хэвлэж гаргана. Нарийн бичгийн дарга санал, гомдлыг хүлээн авч хорооны даргад танилцуулна. Санал, гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, хариуг хүргүүлнэ.

15 дугаар зүйл. Хорооны санхүүжилт

15.1.Хорооны бичиг хэрэг, гишүүдийн цалин хөлс, урамшуулал болон үйл ажиллагааны бусад зардлыг МУИС тухайн жилийн эрдэм шинжилгээний төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

15.2.Өргөдөл мэдүүлэгчийн төлөх хураамжийн хэмжээ, зарцуулалтын хуваарилалтыг МУИС-ийн захирлын тушаалаар батална.

15.3.Хорооны гишүүд гадаад, дотоодод судалгааны ажлын ёс зүйн чиглэлээр хуралд оролцох, сургалтад хамрагдах, мэргэжил дээшлүүлэхэд төв болон бүрэлдэхүүн/салбар сургуулиас дэмжлэг үзүүлнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### СУДАЛГААНЫ АЖЛЫН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ, ХАРИУЦЛАГА

16 дугаар зүйл. Судалгааны ажлын ёс зүйн зөрчил

16.1.Энэхүү журамд заасан судалгааны үнэт зүйлс, зарчмыг баримтлаагүй, судалгааны ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөөгүй, зөрчсөн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйг судалгааны ажлын ёс зүйн зөрчил гэж үзнэ.

16.2.Судалгааны ажлын ёс зүйн зөрчил гаргасан МУИС-ийн гишүүн нь “МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм”-д заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

16.3.Хамтарсан судалгааны хүрээнд судалгааны ажлын ёс зүйн зөрчил гаргасан үйлдэл нь МУИС-ийн гишүүн бус этгээдтэй хамтын ажиллагааг зогсоох, дуусгавар болгох үндэслэл болно.

17 дугаар зүйл. Гомдол гаргах, гомдлын харьяалал

17.1.Өргөдөл мэдүүлэгч этгээд нь Хорооны дүгнэлт, аливаа шийдвэрийг бүхэлд нь болон хэсэгчлэн хүлээн зөвшөөрөхгүй байгаа нөхцөлд “МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм”-ийн 10-р бүлэгт заасны дагуу МУИС-ийн Ёс зүйн хороонд гомдол гаргана.

17.2.МУИС-ийн Ёс зүйн хорооны зүгээс энэхүү журам болон “МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм”-ийн дагуу гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.

17.3.МУИС-ийн Ёс зүйн хорооны шийдвэр нь “МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм”-ийн 43 дугаар зүйлийн 43.13 дахь хэсэгт заасны дагуу эцсийн шийдвэр байна.

18 дугаар зүйл. Судалгааны ёс зүйн зөрчлийн учирсан үр дагаврыг хариуцах

18.1.Энэхүү журамд заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөний улмаас учирсан хохирлыг буруутай этгээд биечлэн хариуцна.

18.2.Судалгааны ажлын ёс зүйн зөрчил гаргасны улмаас МУИС-д учруулсан эд хөрөнгийн хохирлыг хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу гэм буруутай этгээд хариуцна.

18.3.Судалгааны ажлын ёс зүйн зөрчилтэй судалгааны үр дүн, тайланг нийтэд дур мэдэн мэдээлсэн, МУИС-ийн судалгааны үр дүн байдлаар нийтэд мэдээлсэн, гадаад улсад илгээсэн, тайлагнасан, хувийн зорилгоор ашигласны улмаас үүссэн үр дагавар, бусдад учруулсан гэм хор, хохирлыг тухайн буруутай этгээд бие даан хариуцна.

19 дүгээр зүйл. Судалгааны ёс зүйн хяналтын хорооны гишүүнд хүлээлгэх ёс зүйн хариуцлага

19.1.Хорооны гишүүн нь МУИС-ийн эрх ашгийг нэн тэргүүнд баримтлан хөндлөнгийн нөлөөгүй, хараат бусаар шийдвэр гаргаж ажиллах бөгөөд дүгнэлт, шийдвэр гаргахдаа ашиг хонжоо харах, эрх мэдлээ урвуулан ашиглахаас ямагт сэргийлж ёс зүйн зөрчил, алдаа гаргахаас зайлсхийж ажиллах бөгөөд ашиг сонирхлын зөрчлөөс ямагт ангид байна.

19.2.Хорооны гишүүн нь энэхүү журам болон “МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм”-ийг баримтлан ажиллах бөгөөд зөрчсөн нөхцөлд “МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм”-д заасан хариуцлага тооцно.

19.3.Хорооны гишүүн ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон, хичээлийн жилд хорооны хурлын 1/3-ийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан нөхцөлд Хорооны гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох үндэслэл болох бөгөөд дахин хорооны гишүүнээр сонгохгүй.

## ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

20 дугаар зүйл. Судалгааны ажлын ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх

20.1.Энэхүү журмыг МУИС-ийн Ректорын тушаалаар баталснаар хүчин төгөлдөр болж дагаж мөрдөнө.

20.2.Энэхүү журам хүчин төгөлдөр болсноор МУИС-ийн гишүүн, хүрээлэн, төвийн судлаач, эрдэм шинжилгээний ажилтнууд, МУИС-ийн гишүүн бус, МУИС-тай судалгааны харилцаанд оролцож буй этгээдүүд судалгааны ажлын ёс зүйн үнэт зүйлс, үзэл баримтлал, зарчим, хэм хэмжээг чандлан баримталж судалгааны үйл ажиллагаандаа хэлбэрэлтгүй сахина.

20.3.Тус журмыг хүчин төгөлдөр болохоос өмнө МУИС-ийн гишүүн, хүрээлэн, төвийн судлаач, эрдэм шинжилгээний ажилтнуудын эхлүүлсэн судалгаанд тус журмыг нөхөн хэрэглэхгүй буюу нөхөж дүгнэлт, зөвшөөрөл олгохгүй.

20.4.Энэхүү журамд заасан судалгааны ажлын ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх, хэрэгжүүлэхтэй холбоотой удирдамж, нэр томъёоны тайлбарыг хавсралтад дэлгэрэнгүй тусгана. Нэгэн адил журмын адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

21 дүгээр зүйл. Журмын хэрэгжилтэд хяналт тавих

21.1.Энэхүү журмын хэрэгжилтэд МУИС-ийн судалгаа, инновацын бодлогын нэгж байнгын хяналт тавьж, сайжруулах санал, дүгнэлт гарган, хичээлийн жил бүр МУИС-ийн Эрдмийн зөвлөлд тайлагнаж хэлэлцүүлнэ.

22 дугаар зүйл. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

22.1.Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг МУИС-ийн гишүүд төлөөллийн байгууллагаараа дамжуулан МУИС-ийн судалгаа, инновацын бодлогын газарт гаргана.

22.2.Энэхүү журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийг МУИС-ийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж, МУИС-ийн Ректорын тушаалаар баталгаажуулна.

--- оо О оо --

